# Аймгийн намын хорооны III бүгд хурлын тогтоол.

## МАХН-ын Төв Хорооны V бүгд хурлын дүн ба аймгийн намын байгууллагуудын зорилтын тухай

(төгсгөл)

Мал аж ахуйд тэжээл,байр,арчилгаа, маллагааны сайн нөхцөл нэвтрүүлж элдэв зүй бусын хорогдол,өвчинтэй тэмцэх ажил хангалтгүй байгаагаас өнгөрөгч онд зүй бусын хорогдлоор олон мал хорогдуулжээ.

Одоогийн ажил дээр ч гэсэн нэгдэл сангийн аж ахуйнууд төл хүлээн авах бэлтгэлийг хагас дутуу хийж,хаврын тариалалтанд бэлтгэх, техник засварлалтын ажил удаашралтай байна.

Аймгийн улс, ардын аж ахуй, соёлын төлөвлөгөөт зорилтуудыг амжилттай биелүүлэх,ард түмнийг соёлжуулахад хөдөө аж ахуй нэгдлийн бригад,суурь, сангийн аж ахуйн бригад,тасаг,ферм,үйлдвэрлэлийн үндсэн нэгж дэх намын хэсэг, худалдааны агентын ажлыг эрс сайжруулах шаардлагатай байна.

Аймгийн намын III бүгд хурлаас ТОГТООХ нь :

Нэг.ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын коммунист ажилчны намын Төв Хороодын нэгдүгээр нарийн бичгийн дарга,засгийн газрын тэргүүн нарын 1963 оны 7 дугаар сарын зөвлөлгөөний дүнгийн тухай МАХН-ын Төв Хорооны V бүгд хурлаас гаргасан шийдвэрийг аймгийн намын бүгд хурлаас сайшаасугай.

Хоёр.Намын ариун үйл ажиллагаанд хор хохирол учруулахад хүрсэн намч бус,бузар үйл ажил явуулж байсан Л.Цэндийг намын удирдлагаас зайлуулсан МАХН-ын Төв Хорооны V бүгд хурлын шийдвэрийг аймгийн намын бүгд хурал санал нэгтэй дэмжсүгэй.

Гурав.Аймгийн намын хорооны товчоонд даалгах нь:

1.Аймаг орны барилга байгуулалтын ажиллагаанд тавих намын хяналтыг улам хүчтэй болгохын тулд аймгийн намын хороонд мэргэжлийн хүмүүсийн оролцоотой орон тооны бус хэлтэс байгуулан ажиллуулсугай.

2.Аймгийн барилга байгуулалын ажлыг шуурхай далайцтай явуулах зорилгоор аймгийн нам, улс, олон нийт,аж ахуй, соёлын бүх байгууллага нийт хөдөлмөрчдийн хүчийг барилгын ажилд бүрэн чиглүүлж удирдсугай.

Дөрөв. Аймгийн барилга контор нөхөр Лхагваа, намын үүр нөхөр Банзрагч нарт даалгах нь :

1.Аймгийн төвд баригдах 36 айлын сууцны барилгыг 6 дугаар сараас эхлэн 12 сард,120 хүүхдийн яслийн барилгыг 3 дугаар сараас 8 дугаар сард Алтанбулаг сумын төвд баригдах үржил зохиомол хээлтүүлгийн станцын барилгыг 2 дугаар сараас эхлэн 9 дүгээр сард ашиглалтанд оруулахаар шаардагдах бүх материалыг бүрэн бэлтгэх.

2.Барилгын техник талбайн зохион байгуулалтыг сайн хийж машин механизмуудын хүчин чадлыг бүрэн ашиглах,барилгын үйлдвэрлэлийг механикжуулах, материал бэлтгэх бригад байгуулах, норм тарифийн шинэ сүлжил нэвтрүүлэн хөдөлмөрийн бүтээлийг өндөржүүлэх,өөрийн өртгийг хямдруулах барилгыг үйлдвэрлэлийн аргаар барих зэрэг аргуудыг ажилдаа нэвтрүүлэх.

3.Аймгийн барилгачдын зөвлөлгөөнийг угтаж материал бэлтгэх, татах цогцтой ажил явуулах,материал хэмнэх,орон нутгийн хямд материал ашиглах, барилгачдыг курсээр бэлтгэх мэргэжил эзэмшүүлэх, зэрэг ахиулах, хөдөлмөр зохион байгуулалт,хөдөлмөр хамгааллыг сайжруулах, ажлын хариуцлага,сахилга батыг эрс сайжруулах,сан техникийн бригад бий болгох,сан техник, монтажийн ажлыг чанартай хийх, тоо бүртгэл нэвтрүүлэх, тэргүүний туршлага шинэ санаачлагыг дэлгэрүүлэх, социалист уралдааныг өрнүүлж, социалист хөдөлмөрийн бригадын ба төлөө бригадын хөдөлгөөнийг эрчимтэй өрнүүлж, барилгачдыг хүмүүжүүлэх ажлыг сайжруулах.

ТАВ.Хөдөө аж ахуйн нэгдлүүдэд барилгын байнгын бригад байгуулах,нэгдлийн барилгачдад мэргэжил олгох, нэгдэл дундын модны үйлдвэрийг өргөтгөн,техник механизм тоног төхөөрөмж, ажиллах хүчээр хангах,бололцоотой нэгдлүүдэд барилгын модон материал үйлдвэрлэл байгуулах, нэгдлийн барилгуудын улаан булан,контор, халуун ус, хээлтүүлгийн байр зэргийг нэг загварын зураг төсөвтэй болгохыг аймгийн хөдөө аж ахуйг удирдах газар нөхөр Сэтэвт даалгасугай.

Зургаа. Барилга байгуулалтын ажил нийт ард түмний үйл хэрэг мөн гэсэн намынхаа дайчин шийдвэрийг өргөн сурталчилж барилгад ажиллах хөдөлгөөнийг өрнүүлэн тэргүүний хүмүүсийг барилгад урт богино хугацаагаар шилжүүлэн ажиллуулах ба ажиллах хүчний резревийг судлахыг ХЗЭ-ийн Хороо,нөхөр Товуу,Үйлдвэрчний Эвлэлийн Зөвлөл нөхөр Лувсандорж,сумдын АДХ-ын Гүйцэтгэх захиргаадад даалгасугай.

Долоо.Аймгийн төвд баригдах барилгын явцыг түргэтгэх зорилгоор байгууллага, тус бүрээр ажилчин албан хаагчдыг барилгын ямар нэгэн мэргэжилд сургаж, барилгын ажилд туслуулж арга хэмжээ авахыг ҮЭЗ-ийн нөхөр Лувсандоржид даалгасугай.

Найм. Барилгын гадаад материалыг нэгдлүүдэд сисмемтэйгээр хуваарлаж,зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг аймгийн төлөвлөгөөний комисс нөхөр Дондогдорж,худалдаа бэлтгэлийг удирдах газар нөхөр Гончиг нарт даалгасугай.

Ес. Сум—нэгдэл, САА, үйлдвэр, албан газруудын дэргэдэх намын үүр, хороодын нарийн бичгийн дарга нарт даалгах нь:

1. ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын амьдралын баялаг туршлага, шинжлэх ухаан, техникийн шинэ шинэ ололт, социалист эдийн засгийн удирдах тэргүүний арга барилыг байнга судлаж хөдөлмөрчдөд өргөн сурталчлах ба ажилдаа хэрэглэх.

2. МАХН-ын Төв Хорооны V бүгд хурлын шийдвэрийг намын гишүүд, орлогчид, хөдөлмөрчдөд гүнзгий судлуулж аж ахуйг удирдах намын удирдлагын ажлын дутагдлыг шийдвэртэй арилгах.

3. Социалист уралдааныг намын байгууллагууд гардан удирдаж сумдад бүсчилсэн уралдааныг зохион байгуулж намын хороо,АДХ-ын гүйцэтгэх захиргааны оролцоотойгоор улирал дутамд дүгнэж байх.

4. Улс ардын аж ахуйн төлөвлөгөөт зорилтыг биелүүлэхэд олон түмний идэвхтэй санаачлагыг өрнүүлж, улсын төлөвлөгөө, даалгавар, графикийг удирдамж болгон сумдыг аль болохоор биелааж, гүйцэтгэлийн шалгалтыг тогтмол явуулж байх.

5. Нам, төрийн ажлыг аж ахуй уруу хандуулах явдлыг улам хүчтэй болгож, аж ахуйн зорилтыг амжилттай биелүүлэхийн үндэс болсон намын зохион байгуулалт үзэл суртлын ажлыг нягт холбож, дотоод ажил, сайжруулах арга хэмжээг аж ахуйн зорилтоос салгаж орхигдуулахгүйгээр ажиллах.

6. Харъяа барилгын салбаруудын ажлыг өдөр дутмын шуурхай удирдлагаар хангаж тэнд намын хяналт шалгалтыг сайжруулан, захиалагч байгууллагын хяналт туслалцааг хүчтэй болгон хүн хүчээр туслах бригадын ажилд нам, эвлэлийн гишүүдийн манлайллыг эрс сайжруулж ажиллах.

7. Барилгын үйлдвэрлэлд хяналт тавих намын комисс, залуучуудын эвлэлийн хяналтын постын ажлыг сайжруулах.

8. Малаа өсгөсөн амжилтыг улам бататгаж, энэ онд цаг агаарын хүнд нөхцөлийг даван туулж, нэгдэл, САА, бригад, ферм бүр малаа өсгөж, үр тарианы улсын төлөвлөгөөг амжилттай биелүүлж, гарсан төлийг амжилттай бойжуулах зорилтыг хангасугай.

9. Малын зүй бусын хорогдолтой тэмцэж, өвчтэй малын тэжээл, арчилгааны суурин цэгийг мал аж ахуйн бригад бүрт байгуулсугай.

10. Хаврын тариалангийн бэлтгэл техник засварыг 3 дугаар сарын 1-ий дотор шуурхайлан дуусгаж үр, шатах, тослох материалыг хүрэлцээтэй бэлтгэж хөрс боловсруулалтыг 5 дугаар сарын 1-ний дотср чанартай хийж дуусгах.

11. Үйлдвэр, барилга, тээвэр, холбоо, худалдаа бэлтгэл, соёл гэгээрэл, эрүүлийг хамгаалах арга хэмжээний 1964 оны төлөвлөгөөнүүдийг жигд сайн биелүүлэх.

Арав. Аймгийн 1964 оны төлөвлөгөөт зорилтыг амжилттай биелүүлэхэд тус аймгийн ХЗ Эвлэл, үйлдвэрчин, эмэгтэйчүүд, МЗНН орон нутгийн хурлын депутат, байнгын комиссууд, намын хяналтын комисс, эд хэрэглэгчдийн нийгэмлэг зэрэг олон нийтийн байгууллагуудын ажлын туслалцааг аж ахуйн бүх салбарт тодорхой болгосугай.

Арван нэг. Аймгийн 1964 оны төлөвлөгөөт зорилтуудыг хангаж хүн амыг соёлжуулахад суурь, бригад, тасаг ферм, түүний дэргэдэх намын хэсэг, худалдааны агентын ажлыг эрс сайжруулахыг аймгийн намын бүгд хурлаас дэвшүүлж доорх арга хэмжээнүүдийг авч явуулсугай.

а. Төлөвлөгөөт ажлын хувь заяа шийдвэрлэхэд чухал рольтой суурь, бригад, тасаг, фермд үйлдвэрлэлийн аргачилсан удирдлага намын үзэл суртал зохион байгуулалтын ажлын ихээхэн хэсгийг төвлөрүүлж малчид тариачид зэрэг жинхэнэ үйлдвэрлэгчдийн гүн дотор ажиллах асуудлыг эрс сайжруулах.

б. Суурь, бригад, ферм, хэсгүүдийг өдөр дутмын удирдлагаар хангаж байхын тулд бригад хэсэг сууриудын ажлыг тогтмол шалгаж бригадын зөвлөл, хэсэг суурийн ахлагч нарын үйлдвэрлэлийн зөвлөлгөөнүүдийг ажил төрлийн тодорхой асуудлуудаар хийлгэж байх.

в. Нэгж бүтээглэхүүнийг үйлдвэрлэхэд зарцуулж байгаа хөдөлмөр, материалын зардлыг бүртгэн тооцох ажлыг сайжруулж, намын үзэл суртал, зохион байгуулалтын ажлыг үйлдвэрлэгч нэг бүрт хүрэлцүүлэн үйлдвэрийн даалгаврыг амжилттай биелүүлэхэд нөлөөлөх хүч чадлыг дээшлүүлж, хүн нэг бүртэй цуцалтгүй ажиллах.

г. Сууриудад зохиогдох хүмүүжил олон түмний ажилд шилдэг хэлбэрүүдийг өргөн ашиглаж улсын төлөвлөгөөг биелүүлэх хөдөлмөрчдийг соёлжуулахад бүрэн чиглүүлж, тогтмолжуулан сайжруулах.

д. Үйлдвэрлэн бүтээгч малчид тариачдын хөдөлмөрийн идэвх, хөдөлгөөнийг улам өрнүүлэх зорилгоор бригад, тасаг, суурь, ферм, суурийн үйлдвэрлэлийн, даалгаврын биелэлтээр аймаг, сумандаа тэргүүний бригад, суурь, тасаг, ферм болох хөдөлгөөнийг өрнүүлэх.

е. Мал аж ахуйн сууриудыг нам, залуучуудын эвлэлийн гишүүд, депутат зэрэг бусад тэргүүний идэвхтнүүдэд хариуцуулан өгч, суурийг тохижуулж сайжруулах.

Намын хэсгийн зохион байгуулагчдыг намын үүр, хороодоос удирдах ажлыг эрс дээшлүүлж, намын хэсгүүдийн ажлын ололт туршлагыг судлан дэлгэрүүлж заавар зөвлөлгөө өгч байх.

ж. Худалдааны агентын үйлчилгээг сайжруулж, хөдөлмөрчдөд тайлагнуулж, хөсөг уналгаар хангаж, худалдаа бэлтгэлийн төлөвлөгөөг биелүүлэхэд тэдний үүрэг хариуцлагыг дээшлүүлэхийн хамт агентуудын мэргэжил дээшлүүлэх, туршлага солилцуулах зөвлөлгөөн семинарыг сумдад үе, үе хийлгэж байсугай.

Аймгийн намын байгууллагуудын зохион байгуулалт, үзэл суртлын ажлын хэмжээг сайжруулах, үйлдвэрлэлийн нэгжүүдийн ажлын арга барилыг зохих шаардлагын хэмжээнд хүртэл өндөржүүлэн 1964 оны улс, ардын аж ахуй, соёлын төлөвлөгөөт зорилтыг хугацааны нь өмнө амжилттай биелүүлэхэд бүх хүч, бололцоо, авьяас чадлаа бүрэн дайчлаж хөдөлмөрийн гялалзсан амжилт гаргахыг тус аймгийн нам, улс, олон нийт, үйлдвэр, аж ахуй, соёл гэгээрэл эрүүлийг хамгаалах байгууллагууд, намын гишүүд, орлогчид, бүх хөдөлмөрчдөд бүгд хурлаас уриалж байна.